Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд төсвийн шинэчлэлтэй холбоотойгоор гарсан Засгийн газрын "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах" тухай 2022 оны 91, 2022.06.29-ны өдрийн "Журамд өөрчлөлт оруулах тухай" 252-р тогтоол, салбарын сайдын "Заавар батлах тухай" 2022.05.12-ны өдрийн А/170, "Журам шинэчлэн батлах тухай" 2022.11.14-ны өдрийн А/465, "Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай" 2022.04.01-ний өдрийн А/122 "Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам" 2022.10.26-ны өдрийн А/430, БШУС, Эрүүл мэндийн сайдын хамтарсан "Багшийн эрүүл мэндийн талаар авах арга хэмжээний тухай" 2022.06.29-ны өдрийн А/238, А/340 зэрэг тушаал шийдвэрүүд шинээр батлагдсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургууль нь дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн БШУЯ-ны дотоод аудит хэрэгжүүлдэг бөгөөд тус сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургууль нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

## 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод төсвийн шинэчлэлтэй холбоотой хэмнэгдсэн зардлыг төсөвт төвлөрүүлэхгүй мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлээр бүртгэлд тусган тайлагнасан байна.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 2,992,805.8 мянган төгрөг болж өмнөх оноос 477,921.1 мянган төгрөгөөр буюу 15.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 217,429.90 | 217,429.90 |
| Авлага | 0 | 0 | 0.00 |
| Бараа материал | 421.50 | 45,640.00 | 45,218.50 |
| Үндсэн хөрөнгө | 2,887,630.00 | 3,235,931.00 | 348,301.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | -553,741.70 | -642,111.70 | -88,370.00 |
| **Нийт хөрөнгө** | **2,514,884.70** | **2,992,805.80** | **477,921.10** |
| Өр төлбөр | 0 | 0 | 0.00 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,627,034.80 | 1,627,034.80 | 0.00 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,514,884.70** | **2,992,805.80** | **477,921.10** |

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 217,359.9 мянган төгрөг болж өссөн нь төсвийн шинэчлэлтэй холбоотой хэмээгдсэн зардлыг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхгүй мөнгөн хөрөнгийн дансанд үлдэгдлээр тайлагнадаг болсонтой холбоотой ба цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 182,158.2 мянга, ажил олгогчийн НДШ-ын зардалд 23,446.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 5,791.1 мянга, үдийн цайны зардалд 7,486.6 мянган төгрөгийн хэмнэлт тус тус үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 45,640.0 мянган төгрөг болж өмнөх оноос 45,218.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 61,123.5 мянга, гүнзгийн ангийн сурах бичиг 3,282.4, түрээсийн болон нөхөн хангалтын сурах бичиг 9,285.9 мянга, Нарлаг Улаанбаатар Ротари олон улсын сангийн GG 2231435 дугаар бүхий Грант төслийн хөрөнгө оруулалтаар Хими,

Физикийн сургалтын хэрэглэгдэхүүн 18,729.9 мянга, өмнөх аудитын зөвлөмжөөр 3,605.8 мянган төгрөгийн эм боох материал үнэ төлбөргүй орлогоор авсан, 146,401.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үүнээс тусгай зориулалтын материал 32,626.6 мянга, бусад хангамжийн материал 17,916.2 мянга төгрөгөөр өссөн голлох нөлөө үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,235,931.0 мянган төгрөг болж өмнөх оноос 348,301.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн шинэчлэлтэй холбоотой нөхөн хангалтын зардлын санхүүжилтээр ерөнхий гэрээний дагуу худалдан авсан 44,493.2 мянган төгрөгийн цахим танхимын таблет төсвийн хөрөнгөөр худалдан авсан, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 138,416.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 23,225.9 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, хандиваар Нарлаг Улаанбаатар Ротари олон улсын сангийн GG 2231435 дугаар бүхий Грант төслийн хөрөнгө оруулалтаар Хими, Физикийн 4,199.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 16,003.9 мянган төгрөгийн тавилга хэрэгслийг данс бүртгэлд орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Авлага дансны эцсийн үлдэгдэл 45,218.5 мянган төгрөг болж өссөн нь ерөнхий гэрээний дагуу нөхөн хангалтын зардлаас худалдан авалт хийсэн тоног төхөөрөмж тайлант онд багтаж ирээгүйтэй холбоотой авлага үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,627,034.80 мянган төгрөг болж 340,129.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 340,129.6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,278,301.5 мянга төгрөгийг зарцуулахаар тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 358,975.6 мянган төгрөгөөр бууруулж 1,919,325.9 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 2,143,821.9 мянган төгрөг болгож 225,496.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Энэ нь төсвийн шинэчлэлтэй холбоотой сургуулийн суралцагчдын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож багш нарын үндсэн цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 хөтөлбөрийн 80226, 80312, 81605, 81801, 81816, 81823, 81834, 81835, 81844, 81848, 80112 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,331,664.2 мянган төгрөгийн төсөв батлснаас 897,312.8 мянган

төгрөгийг улсын төсвөөс 434,351.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,143,821.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 258,990.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд улсын төсвөөс 2,164,441.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 258,409.3 мянган төгрөгийг зарцуулж 581.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн болно.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,286,904.7 мянган төгрөг буюу 91.3 хувьтай байгаа нь улсын төсвийн урсгал зардлыг 217,359.9 мянган төгрөгөөр, орон нутгийн урсгал зардлыг 581.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* /мянган төгрөгөөр/

| № | Код | Хөтөлбөр арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 80226 | Байр ашиглалтын үйлчилгээний зардал | 7,147.30 | 7,141.02 | 6.28 | 99.9 |
| 2 | 80312 | Сургалт семинарын зардал | 3,573.60 | 3,525.00 | 48.60 | 98.6 |
| 3 | 81605 | Эрүүл мэндийг дэмжих зардал | 8,219.40 | 4,521.20 | 3,698.20 | 55.0 |
| 4 | 81801 | Үдийн цай хөтөлбөр | 138,502.10 | 131,015.50 | 7,486.60 | 94.6 |
| 5 | 81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчны зардал | 89,910.00 | 89,885.76 | 24.24 | 100.0 |
| 6 | 81823 | Боловсролын байгууллагын багшийн хөгжлийн сургалтын зардал | 16,081.40 | 16,042.70 | 38.70 | 99.8 |
| 7 | 81834 | Боловсролын стандарт, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардал | 1,771,194.90 | 1,597,960.61 | 173,234.29 | 90.2 |
| 8 | 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардал | 109,193.20 | 76,921.18 | 32,272.02 | 70.4 |
| 9 | 81844 | Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын зардал | 14,249.30 | 12,329.87 | 1,919.43 | 86.5 |
| 10 | 81848 | Сурах бичгийн түрээсийн орлого | 6,369.90 | 6,369.40 | 0.50 | 100.0 |
| 11 | 80112 | Нийтлэг үйлчилгээний зардал | 258,990.50 | 258,990.50 | 0.00 | 100.0 |
| | | **Нийт** | **2,423,431.60** | **2,204,702.75** | **218,728.85** | **91.0** |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100031915401 дансаар Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг үзүүлэх 5 жилийн тэтгэмж 81,868.8 мянга, FACE FORM Төслийн уралдааны санхүүжилт 500.0 мянга, Гал тогооны түрээсийн зардалд 1,483.0 мянган төгрөг төвлөрүүлэн холбогдох зардалд зарцуулан үлдэгдэл 1,483.0 мянган төгрөгийг үндсэн дансанд шилжүүлсэн байгаа.

*Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого* */мян.төгрөгөөр/*

| д/д | Орлогын төрөл | Авсан санхүүжилт |
|---|---|---|
| 1 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 81,868.8 |
| 2 | FACE FORM Төслийн уралдааны санхүүжилт | 500.0 |
| 3 | Түрээсийн орлого | 1,483.0 |
| | **Нийт орлогын дүн** | 83,852.1 |
| 1 | УТ-ын дансанд төвлөрүүлсэн | 1,483.3 |
| 2 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 81,868.8 |
| 3 | Усны сургалтын төлбөр | 500.0 |
| | **Нийт зарлагын дүн** | 83,852.1 |

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цэзэням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дугээр сарын 21-ны өдрийн 172 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн захирал Ц.Загдсүм, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Төмөрхуяг нар зурж байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 2,847,693.3 мянган төгрөгөөс 35,546.5 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 24,882.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

*Хүснэгт 4. Шилэн дансны мэдээлэл*

| Д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлбэл зохих/ удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Мэдээлэл байршуулаагүй | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 7 | 1 | 0 | 3 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | 0 | 0 |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | 0 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | 0 | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 96 | 0 | 0 | |
| Нийт | | 27 | 151 | 147 | 1 | 0 | 3 |

*Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн систем*

Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 151 мэдээллээс худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бүтэн жилээр мэдээлэх 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 177,428.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 92,880.0 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 1,131.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 59,616.0 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага өгч, 23,800.0 мянган төгрөгийн 5 зөрчилд алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 84 тоот албан бичгээр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

*Хүснэгт 5. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1,131.9 | 1 | 1,131.9 | 100 |
| Албан шаардлага | 3 | 59,616.0 | 1 | 59,616.0 | 100 |
| Зөвлөмж | 5 | 23,800.0 | 5 | 23,800.0 | 100 |
| **Нийт дүн** | **9** | **177,428.7** | **9** | **177,428.7** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол "Хоолны зардлын норматив тогтоох тухай"-ын 4-т "Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх"-ыг БШУС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 оны 1, 2 дугаар саруудад бүрэн ажиллаагүй, хоолны ирцэд хяналт тавьснаар Үдийн цай хөтөлбөрийн зардал 7,486.6 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй ба харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,889.0 мянган төгрөгийн зөрчилд[1] алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлэв.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***<u>Өгсөн зөвлөмж</u>:***

1. Тайланд хугацаанд Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 1080.0 мянган төгрөгийн албан томилолт, Мэдээлэл технологийн зардлаас 4,809.0 мянган

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төгрөгийн компьютер засвар, сургуулийн интернэт сүлжээний засварт тус тус худалдан авч батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; ЗГ-ын 2022.03.02-ны өдрийн 91 дугаар тогтоол, БСШУС-ын 2022.05.12-ны өдрийн А/170 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дээд шатны байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг мөрдөн ажиллах алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

2. Тайлант хугацаанд 45,218.5 мянган төгрөг болж өссөн нь ерөнхий гэрээний дагуу нөхөн хангалтын зардлаас худалдан авалт хийсэн тоног төхөөрөмж тайлант онд багтаж ирээгүйтэй холбоотой авлага үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид төсвийг зохистой удирдан зохион байгуулж авлага үүсгэхгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Тайланд хугацаанд Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 1080.0 мянган төгрөгийн албан томилолт, Мэдээлэл технологийн зардлаас 4,809.0 мянган төгрөгийн компьютер засвар, сургуулийн интернэт сүлжээний засварт тус тус худалдан авч батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. | 1 | 5,889.0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 5,889.0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2 | Тайлант хугацаанд 45,218.5 мянган төгрөг болж өссөн нь ерөнхий гэрээний дагуу нөхөн хангалтын зардлаас худалдан авалт хийсэн тоног төхөөрөмж тайлант онд багтаж ирээгүйтэй холбоотой авлага үүссэн байна. | 1 | 45,218.5 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 45,218.5 | | | | |
| | **Нийт дүн** | **2** | **51,107.5** | **0** | **0** | **0** | **0** | **1** | **51,107.5** | **0** | **0** | **0** | **0** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | 0 | 0 | | | | | 0 | 0 |
| | | | | | | | | |
| Дүн | 0 | 0 | | | | | 0 | 0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 0 | 0 | | | | | 0 | 0 |

oOo

*Эрдэм сургууль*

# ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

*2022 он 12 сар 31 өдөр.* */төгрөгөөр/*

| | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 1. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,423,431,600.00 | 2,286,904,597.79 | 136,527,002.21 | 94.4% |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 2,423,431,600.00 | 2,286,904,597.79 | 136,527,002.21 | 94.4% |
| Бараа, үйлчилгээний зардал | 2,284,929,500.00 | 2,074,020,303.79 | 210,909,196.21 | 90.8% |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | 1,655,452,700.00 | 1,473,294,411.78 | 182,158,288.22 | 89.0% |
| Үндсэн цалин | 1,206,746,500.00 | 1,027,381,125.78 | 179,365,374.22 | 85.1% |
| Нэмэгдэл | 390,679,500.00 | 386,160,809.00 | 4,518,691.00 | 98.8% |
| Урамшуулал | 26,381,400.00 | 28,176,933.00 | (1,795,533.00) | 106.8% |
| Гэрээт ажлын хөлс | 31,645,300.00 | 31,575,544.00 | 69,756.00 | 99.8% |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 207,431,700.00 | 183,985,681.67 | 23,446,018.33 | 88.7% |
| Тэтгэврийн даатгал | 141,073,500.00 | 127,143,253.51 | 13,930,246.49 | 90.1% |
| Тэтгэмжийн даатгал | 16,594,600.00 | 15,037,187.85 | 1,557,412.15 | 90.6% |
| ҮОМШӨ-ийн даатгал | 13,255,700.00 | 10,196,895.95 | 3,058,804.05 | 76.9% |
| Ажилгүйдлийн даатгал | 3,318,900.00 | 1,985,464.47 | 1,333,435.53 | 59.8% |
| Эрүүл мэндийн даатгал | 33,189,000.00 | 29,622,879.89 | 3,566,120.11 | 89.3% |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 221,889,500.00 | 221,887,520.00 | 1,980.00 | 100.0% |
| Гэрэл цахилгаан | 8,505,200.00 | 10,106,153.00 | (1,600,953.00) | 118.8% |
| Түлш, халаалт | 184,241,800.00 | 184,241,471.00 | 329.00 | 100.0% |
| Цэвэр, бохир ус | 29,142,500.00 | 27,539,896.00 | 1,602,604.00 | 94.5% |
| Эд хогшил худалдан авах | 1,000,000.00 | 999,200.00 | 800.00 | 99.9% |
| Урсгал засвар | 1,000,000.00 | 999,200.00 | 800.00 | 99.9% |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 24,238,100.00 | 24,727,126.34 | (489,026.34) | 102.0% |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,369,900.00 | 6,869,400.00 | (499,500.00) | 107.8% |
| Мэдээллийн технологийн зардал | 17,868,200.00 | 17,857,726.34 | 10,473.66 | 99.9% |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 174,917,500.00 | 169,126,364.00 | 5,791,136.00 | 96.7% |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 148,115,100.00 | 142,371,004.00 | 5,744,096.00 | 96.1% |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 26,802,400.00 | 26,755,360.00 | 47,040.00 | 99.8% |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 138,502,100.00 | 212,884,294.00 | (74,382,194.00) | 153.7% |
| Бусад урсгал шилжүүлэг | 138,502,100.00 | 212,884,294.00 | (74,382,194.00) | 153.7% |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 138,502,100.00 | 131,015,500.00 | 7,486,600.00 | 94.6% |
| Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж | | 81,868,794.00 | (81,868,794.00) | |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,425,431,600.00 | 2,504,897,833.60 | (79,466,233.60) | 103.3% |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,143,821,900.00 | 2,143,821,900.00 | | 100.0% |
| Улсын төсвөөс санхүүжих | 2,143,821,900.00 | 2,143,821,900.00 | | 100.0% |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 258,990,500.00 | 258,990,500.00 | | 100.0% |
| Орон нутгийн төсвөөс | 258,990,500.00 | 258,990,500.00 | | 100.0% |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 22,619,200.00 | 19,734,640.00 | 2,884,560.00 | 87.2% |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,369,900.00 | 6,407,000.00 | 1,962,900.00 | 76.5% |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,249,300.00 | 13,327,640.00 | 921,660.00 | 93.5% |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | | 82,350,793.60 | (82,350,793.60) | |
| Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдаагүй төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 82,350,793.60 | (82,350,793.60) | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 217,359,952.21 | (217,359,952.21) | |
| ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | | |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | | 100.0% |
| Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | | 100.0% |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | 102.00 | 98.00 | 4.00 | 96.1% |
| Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | | 100.0% |
| Гүйцэтгэх ажилтан | 85.00 | 84.00 | 1.00 | 98.8% |
| Үйлчлэх ажилтан | 16.00 | 13.00 | 3.00 | 81.3% |
| СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | 1,414.00 | 1,426.00 | (12.00) | 100.8% |
| Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид | 1,414.00 | 1,426.00 | (12.00) | 100.8% |
| Төрийн өмчит ЕБС | 1,414.00 | 1,426.00 | (12.00) | 100.8% |
| ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО | | | | |
| ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 102.00 | 99.00 | 3.00 | 97.1% |

*2022 он 12 сар 31 өдөр.* *Iтөгрөгөөр/*

| | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО** | | | | |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | 102.00 | 99.00 | 3.00 | 97.1% |
| Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮМБ/ | 81.00 | 80.00 | 1.00 | 98.8% |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/ | 21.00 | 19.00 | 2.00 | 90.5% |

Ерөнхий менежер: ________ */ Ц.Загдсүм /*

Нягтлан бодогч: ________ */ Д.Төмөрхуяг /*

Баталгаажуулсан: ________ / /